



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026 оны 02 сарын 09

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт шинжилгээ,  
үнэлгээний ажлын зорилго**

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг хийлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

**Хоёр. Танилцуулга**

Бодлого төлөвлөлтийн газрын 2025 оны үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, ерөнхий дүнг Хүснэгт №1-д харуулав.

*Бодлого, төлөвлөлтийн газрын  
үйл ажиллагааны ерөнхий дүн*

*Хүснэгт №1*

№	Үзүүлэлт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт хувь	Жин	
1	Бодлогын үр дүн	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	2	65	13
2		Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	
3	Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	90	91.8	18.36
4		Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	53	90.4	18.08
5		Сайдын тушаалын хэрэгжилт	20	100	100
6		Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	30	93.3	9.33

7	Чадамжийн үнэлгээ	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	5	100	10
8		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	-	-	-
9		Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт,	-	-	-
10		Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт,	-	-	-
11		Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт,	-	-	-
12		Байгууллагын ажилтан албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	-	-	-
<b>Нийт</b>			<b>200</b>	<b>90</b>	<b>87.5</b>

**2.1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, эзэнжүүлээгүй байгаа бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Хүснэгт №2-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт*

*Хүснэгт №2*

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин					Биелэлтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	Хугацаа болоогүй	
2	1	-	1	-	-	65%

Эх сурвалж: [www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn)

*Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:*

1. 620. Тээврийн ерөнхий хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Зорилтот түвшин: Арга хэмжээний хэрэгжилтийн хувь -100

Биелэлт: 1.Авто тээврийн тухай хуулийн төслийг боловсруулан зөвлөх үйлчилгээ авахаар Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг батлуулсан. Тээврийн ерөнхий хуулийн төслийг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсэг шинэчлэн байгуулж, удирдамжийн дагуу Олон Улсад жишиг болон хэрэгжиж буй бусад улс орны Тээврийн ерөнхий хууль, ижил төстэй хуулиудыг судлан танилцуулах ажлыг гүйцэтгэсэн.

2.Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/291 дүгээр тушаалаар ажлын хэсгийг шинэчилэн байгуулсан. Хуулийн төслийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа–2050”,

Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ын зорилтуудад тусгагдсан тээврийн ухаалаг систем, нэгдсэн зохицуулалт, тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулж боловсруулсан ба Нийслэлийн Засаг даргаас хуулийн төсөлд шинээр оруулах санал холбогдох судалгааг авахаар ажиллаж байна.

## 2.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд БТГ-тай холбоотой асуудал тусгагдаагүй бөгөөд уг төлөвлөгөөний 1.6-д заасан “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд тус яамнаас авч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, мөн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд туссан төсөл арга хэмжээг эзэнжүүлж, хэрэгжилтэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

## 2.3. Бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 53 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, хэрэгжилт тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж үнэлгээ **91.8** хувьтай байгаа бөгөөд Хүснэгт №3-т харуулав.

### Бодлого, төлөвлөлтийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ

Хүснэгт №3

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
66	53	3	4	3	2	1	-	91.8%

Хэрэгжилт хангалтгүй буюу 0-70 хувийн хэрэгжилттэй арга хэмжээг Хүснэгт №4-т харуулав.

### Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №4

№	Арга хэмжээний заалт, агуулга	Хүрэх түвшин	Хугацаа	Биелэлт	Хувь
<i>“0” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ</i>					
1	<b>Арга хэмжээ 1.15.</b> Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл	<b>I улирал:</b> Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулна. <b>II улирал:</b> 30-аас доошгүй хувьд,	I-II	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2025 оныг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан ССАЖЗЯ-наас ирүүлсэн хөтөлбөрт 2024.12.12-ны өдрийн 03/2180 дугаартай албан бичгээр санал боловсруулан хүргүүлсэн. Мөн Зам тээврийн салбарын залуучуудын зөвлөлтэй хамтран	0

	ажиллагааны төлөвлөгөөг батлуулна.			"Зам, тээврийн салбарын залуу ажилтныг дэмжих хөтөлбөр" боловсруулан Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан.	
<b>"30" хувийн хэрэгжилттэй арга хэмжээ</b>					
2	<p><b>Арга хэмжээ 1.32.</b> Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна.</p>	<p><b>I-II улирал:</b> Зураг төсөл хийлгэх хөрөнгийг шийдвэрлүүлнэ.</p> <p><b>III-IV улирал:</b> Хөрөнгийг шийдвэрлэсний үндсэн дээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна.</p>	I-IV	<p>Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөөнд нийт 8 ажил тусгагдсан ба 91%-тай гүйцэтгэсэн. Зам тээврийн сайдын 2024 оны А/259 дугаар тушаалаар байгуулагдсан "Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах" ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, ажлын хэсгийн гишүүдийн саналуудыг нэгтгэн "Хил дамнасан усан боомт байгуулах боломжгүй ба усан замын зогсоол байгуулж, хил орчмын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх бүрэн боломжтой" гэх нэгдсэн дүгнэлтийг гарсан. Ажлын хэсгийн хоёрдугаар хуралдаан 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж Монгол улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хилийн усны хамтарсан комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх санал гарсныг албажуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 08/570 тоот албан бичгийг хүргүүлсэн. Хилийн боомтын захиргаанд "Буйр нуур" усан замын, улирлын чанартай боомт байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаварт холбогдох санал болон үнэлгээний хороонд орж ажиллах албан хаагчдын мэдээллийг 2025 оны 01/09 тоот албан бичгээр, тус ажлын хэсгээс гарсан нэгдсэн санал, дүгнэлтийг Монгол улсын хилийн боомтын захиргаанд 2025 оны 03/3796 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Хилийн боомтын захиргаа үнэлгээ хорооны байгуулах товыг хүлээж байна.</p>	30

3	<p><b>Арга хэмжээ 2.7.</b> Монгол Улсын “Тээврийн долоо хоног 2025” арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p><b>I-IV улирал:</b></p> <p>Арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргахад оролцоно.</p> <p>Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд урилга, мэдээлэл хүргүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, арга зүйгээр хангана.</p> <p>Гадаадын зочид төлөөлөгчдийг угтах, үдэх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулна.</p> <p>Салбар хуралдаан зохион байгуулахад бусад нэгжүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.</p>	I-IV	<p>Төсвийн хэмнэлт хийх чиглэлийн дагуу арга хэмжээ зохион байгуулах боломжгүй болсон тул хойшлуулсан.</p>	
<b>“50” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ</b>					
4	<p><b>Арга хэмжээ 1.28.</b> Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна.</p>	<p><b>I-II улирал:</b></p> <p>ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэнэ.</p> <p><b>III улирал:</b></p> <p>Хөрөнгийг шийдвэрлэсний үндсэн дээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна.</p>	I-III	<p>Дэлхийн банкны төлөөлөл болон яамны удирдлагууд 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр уулзсан уулзалтаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах хөрөнгийг Дэлхийн банкнаас шийдвэрлүүлэхээр тохирсон. Уулзалтын мөрөөр 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр болон 02 дугаар сарын 12-ны өдөр тус тус уулзан хөрөнгийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэн ЗТЯ-тай хамтран хэрэгжүүлж буй МУ-ын тээврийн сүлжээ, логистикийг сайжруулах төслийн зээлийн санхүүжилтийн хамрах хүрээнд оруулан шийдвэрлэхээр тохирсон. Тус төслийн хүрээнд Олон улсын болон, дотоодын зөвлөх авах шатанд Дэлхийн банктай хамтран ажиллаж, Дэлхий банк зөвлөх томилон өгч ажлын даалгавар боловсруулж байна.</p>	

5	<p><b>Арга хэмжээ 1.29.</b> Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийнэ.</p>	<p><b>I-II улирал:</b> Нөхцөл байдлын үнэлгээ, судалгааны ажлыг эхлүүлнэ.</p> <p><b>III-IV улирал:</b> Нөхцөл байдлын үнэлгээ, судалгааг боловсруулж танилцуулна.</p>	I-IV	<p>Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах судалгааны ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлтийг АХБ-нд уламжилж, 2025 оны 02 дугаар сарын 12-нд ЗТЯ-нд хийсэн уулзалтын үеэр Хөшигийн хөндийн зохион байгуулалтын зураглалыг танилцуулсан бөгөөд АХБ талаас асуудлыг удирдлагуудадаа танилцуулан шийдвэрээ мэдэгдэхээр болсон. 2025 оны 02 дугаар сарын 27-нд Далайн захиргаа болон холбогдох байгууллагууд НЗД-ын удирдлагуудтай уулзаж, Хөшигийн хөндийд олон улсын чанартай хуурай боомт байгуулах боломжит байршлын талаар санал солилцов. Далайн захиргаа нь төмөр зам, дэд бүтэц, логистикийн төвтэй уялдсан байршлыг дэмжиж буйгаа илэрхийлсэн.ЗТЯ болон Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж буй тээврийн сүлжээ, логистикийг сайжруулах төслийн хүрээнд хяналтын зөвлөхийн сонгон шалгаруулалт явагдаж, гэрээний хэлцэл хийгдэж байна. Төслийн зөвлөх үйлчилгээний багт хуурай боомтын асуудал хариуцсан шинжээч томилогдож, ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулж эхлээд байна. Дэлхийн банкнаас боловсруулсан ажлын даалгаврыг ЗТЯ-нд хүргүүлж, батлуулах үйл явцыг зэрэгцүүлэн хэрэгжүүлж байна.Мөн Монгол улсын Далайн захиргаа Төв аймгийн Хөшигийн Хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах олон талт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн суурь судалгааг хийн боловсруулсан.</p>	
6	<p><b>Арга хэмжээ 3.16.</b> Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг хянан сайжруулах цахим</p>	<p><b>I улирал:</b> Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн авто замд цаг уур, тээврийн хяналтын систем бүхий “ТАЦ”-ийг барих болон автотээврийн хэрэгслийн хөдөлгөөн</p>	I-IV	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан-Алтан булаг чиглэлд цахим ТАЦ байгуулж, замын хяналтын камерыг эрсдэл бүхий цэгүүдэд камер, хяналтын тоног төхөөрөмж байршуулах нэг багц тендер, Алтанбулаг болон</p>	50

<p>системүүд нэвтрүүлнэ.</p>	<p>дунд даац хэмжигч авто пүү (WIM) суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлана</p> <p><b>II-III улирал:</b> Нийслэлийн автотээврийн бүртгэл, хяналтын газрын мэдээллийн системүүдийг VRS системд бүрэн холбож бусад системийн хөгжүүлэлтийг хийж, УБ хотын түгжрэлийг бууруулах зорилтод ажлуудыг хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн авто замын цахимжуулалтын ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажлыг эхлүүлнэ.</p> <p>Улсын хэмжээнд ажиллаж буй 27 ТАЦ-ыг бүрэн цахимжуулах ажлын даалгавар, сервер тоног төхөөрөмж худалдан авах ажлуудын ажлын даалгавар болон шинээр баригдах “ТАЦ”-ын ажлын даалгаварт дэвшилтэд технологи нэвтрүүлэх санал тусгана. Олон улсын транзит тээврийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, авто замын хураамжийг зорчсон км тутамд тооцон авах боломжийг бүрдүүлэхэд мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлнэ.</p> <p>“RFID” tag бүртгэлийн апп, “RFID” технологид суурилсан “Зам тээврийн нэгдсэн систем” болон Зам, тээврийн салбарын байцаагчийн торгууль шийтгэврийн систем хөгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, гэрээний</p>	<p>Борнуур орчимд хөдөлгөөн дунд даац хэмжих авто пүү суурилуулах багц тендерүүдийг тус бүр 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зарласан. <a href="https://mrt.gov.mn/i/4445">https://mrt.gov.mn/i/4445</a> <a href="https://mrt.gov.mn/i/4444">https://mrt.gov.mn/i/4444</a></p> <p>Энэхүү 2 тендерт тус бүр нэг оролцогч бүртгүүлсэн ба тендерийн үнэлгээний хороо тендерийг үнэлж тендерүүд шаардлага хангаагүй тул дахин зарлахаар болсон. Үнэлгээний хороо тайлангаа АХБ-нд эцэслэн хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн автотээврийн бүртгэл, хяналтын газрын мэдээллийн системүүдийг VRS системд холбосон ба нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг батлуулсан. Ажлын даалгаврын дагуу хийгдсэн хөгжүүлэлтийн актыг 11 дүгээр сарын 28-ны өдөр үйлдсэн.</p> <p>Улсын хэмжээнд уламжлалт байдлаар ажиллаж буй 21 ТАЦ-ыг бүрэн цахимжуулах ажлын даалгавар, сервер тоног төхөөрөмж худалдан авах ажлуудын ажлын даалгавар болон шинээр баригдах “ТАЦ”-ын ажлын даалгаварт дэвшилтэд технологи нэвтрүүлэх саналыг боловсруулсан ба ажлын даалгаврын дагуу Олон улс, улсын чанартай авто замд RFID технологид хяналт тавих тоног төхөөрөмж суурилуулах тендерийг зохион байгуулж Арш технологи ХХК-тай гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.</p> <p>Улсын байцаагчийн торгууль, шийтгэврийн систем RFID технологид суурилсан гар уншигч дээр суулгах апп хөгжүүлэх тендерийг ТХААГ-аас зарласан ба зөвлөх үйлчилгээг харьцуулалтын аргаар шалгаруулах “ЗТЯ/20250101046” дугаартай тендерийг ТӨХАГ-аас 2025-09-05-ны өдөр зарлаж 2025-09-12-ны өдөр нээсэн. Уг тендерт 1 оролцогч материалаа ирүүлсэн ба оролцогчийн ирүүлсэн материал тендерийн шаардлага хангасан тул Инфокон ХХК-тай гэрээ байгуулсан. Инфокон ХХК-нь програм хөгжүүлэлтийн орчин</p>	
------------------------------	---	--	--

		хэрэгжилтэд хяналт тавина. <b>IV улирал:</b> Тээврийн ухаалаг системийн бүрэлдэхүүн болох “roadpay” систем, тээврийн хэрэгслийн бүртгэлийн “vrs” систем, техникийн хяналтын үзлэгийн “mvis” систем, цаг уур, автотээврийн хяналтын систем “egoad”, авто замын даац хэмжилтийн системүүд хооронд мэдээлэл солилцох холболтыг хийнэ. ТЦА, АТҮТ, ЗТХТ, ЗХУТ, НАТБХГ болон бусад байгууллагуудтай “ХУР” систем болон Зам, тээврийн мэдээллийн нэгдсэн системийг ашиглаж мэдээлэл дамжуулдаг болсон байна.		бүрдүүлж, Үндэсний дата төв дээр серверээ байршуулж, тохиргоог хийсэн. RFID” технологид суурилсан “Зам тээврийн нэгдсэн системийг зохиох зөвлөх үйлчилгээний тендерийг мөн ТХААГазраас зарласан ба нэг ч оролцогч шаардлага хангаагүй тул дахин тендер зарласан ба 11 дүгээр сарын 25-ны өдөр нээсэн.	
<i>“70” хувийн хэрэгжилттэй арга хэмжээ</i>					
7	<b>Арга хэмжээ 1.4.</b> Салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл батлуулна.	<b>I улирал:</b> Зам, тээврийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулна. <b>II улирал:</b> Төлөвлөгөөний төслийг батлуулна.	I-II	Зам, тээврийн салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг газруудаас санал авч тусган, боловсруулсан. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /5 сард/ албажин Legalinfo-д байршантай холбогдуулан уг төлөвлөгөөтэй нийцүүлж, нэмэлт өөрчлөлт оруулах, Зам, тээврийн яамны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр ЗГ-ын 2025 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан тул уг хөтөлбөрт нийцүүлэх ажлууд хийгдээд байгаа бөгөөд МУ-ын 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг УИХ хэлэлцэн батлахтай холбогдуулан уг дунд хугацааны бодлоготой нийцүүлэн батлуулахаар ажиллаж байна.	70
8	<b>Арга хэмжээ 1.7.</b> Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын төлөвлөгөөг батлуулна.	<b>II улирал:</b> Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	II	Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй /уг төлөвлөгөө нь 5 сард албажиж legalinfo-д орсон./ нийцүүлэн боловсруулсан. МУ-ын 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 2025 оны 11 дүгээр сард УИХ-ын байнгын	70

				хороодоор хэлэлцэн 2025-11-28-ны өдөр УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан. Шинэ сэргэлтийн бодлого нь 2030 он хүртэлх бодлого бөгөөд ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын 2026-2030 оны үндсэн чиглэлийн бодлогтой нийцүүлэн боловсруулж батлуулах тул 2025-11-28-ны өдөр УИХ-ын чуулганы хуралдаанаар баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл бодлогын баримт бичгийг албажих хувьтай нийцүүлэн боловсруулж батлуулахаар ажиллаж байна.	
9	<b>Арга хэмжээ</b> 1.8. “Монголд зочлох жил”-ийн салбарын 2025 оны төлөвлөгөөг батлуулна.	<b>I улирал:</b> “Монголд зочлох жил”-ийн 2024 оны зам, тээврийн салбарын төлөвлөгөөг батлуулна.	I	“Монголд зочлох жил”-ийн 2024 оны зам, тээврийн салбарын төлөвлөгөөний төсөлд холбогдох газруудаас дотоод бичгээр, харьяа газруудаас 04/1085 дугаартай албан бичгээр санал авахаар хүргүүлсэн. Ирсэн саналуудыг тусгаж төлөвлөгөөний төслийг, сайдын тушаалын төслийн хамт боловсруулан able-н тушаал шийдвэр хэсэгт байршуулан удирдлагуудаар хянуулсан. Зам, тээврийн сайдын тушаалын төсөл албажих шатанд байна.	70
10	<b>Арга хэмжээ</b> 1.11 Яамнаас 2025 онд УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулна.	<b>I-IV улирал:</b> УИХ-ын чуулган, Засгийн газрын хуралдаанаар 2025 онд хэлэлцүүлэх асуудлыг төлөвлөлтийг улирал бүрээр гарган ЗГХЭГ-т хүргүүлнэ. УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын товын дагуу оруулах ажлыг зохион байгуулсан байна. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөлтийн хэрэгжилтийг 90-ээс доошгүй хувьд хүргэнэ.	I-IV	2025 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулах асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2024.10.10-ны өдрийн 03/1080 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2025 оны 2 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулах асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2025.04.02-ний өдрийн 01/1435 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2025 оны 3 дугаар улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулах асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2025.07.02-ны өдрийн 01/3107 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2025 оны 4 дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулах	70

				асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж 2025.10.20-ний өдрийн 01/4822 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын товыг тухай бүр удирдлагуудад танилцуулан, зохион байгуулж ажилласан.
--	--	--	--	--

#### 2.4. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрээр 53 заалт бүхий үүрэг өгөгдсөн бөгөөд үүнээс хэрэгжсэн 39, хэрэгжих шатанд 3, хэрэгжээгүй 1, хугацаа болоогүй 6 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 90.4 хувьтай байгаа бөгөөд Хүснэгт №5-д харуулав.

*Хууль тогтоомж, тогтоол  
шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ*

*Хүснэгт №5*

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
53	39	3	1	6	-	90.4

Эх сурвалж: [www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn)

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Усан замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-25 дугаар 2017.07.01;

5.1.3. Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн улсын хяналтын дүрмийг батлах;

**Биелэлт:** Хуулийн энэхүү заалтыг МХЕГ хэрэгжүүлэх ба Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар "Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм"-ийг баталсан бөгөөд Усан замын тээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлд "Усан замын тээврийн болон усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагч... Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан.

#### 2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Тайлант хугацаанд Сайдын тушаалаар 20 заалт бүхий үүрэг өгөгдсөн бөгөөд үүнээс хэрэгжсэн 19, хүчингүй болсон 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 100 хувьтай байгаа бөгөөд Хүснэгт №6-д харуулав.

*Сайдын тушаалын хэрэгжилтийн үнэлгээ*

*Хүснэгт №6*

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	

20	19	-	-	-	1	100%
----	----	---	---	---	---	------

### 2.6. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт

Тайлант хугацаанд Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 30 заалт бүхий үүрэг өгөгдсөн бөгөөд үүнээс хэрэгжсэн 27, хэрэгжих шатанд 2, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 93.3 хувьтай байгаа бөгөөд Хүснэгт №7-д харуулав.

#### Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт №7

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
30	27	2	1	-	-	93.3%

Хэрэгжээгүй арга хэмжээ:

1/ Ажлын хэсэг байгуулах тухай 2025.02.25 А/48

1.Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-д өөрчлөлт оруулж төслийг холбогдох хууль, журмын хүрээнд боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулан батлуулахыг Ажлын хэсэг (Г.Батбаяр)-т.

**Биелэлт:** Журмын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтийн саналыг авч, 2025.08.14-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, яамдаас санал авахаар бичгийн төслийг цахимаар 4 удаа тойруулсан.

### 2.7. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт”-ийн дагуу 5 хэсгийн нээлттэй мэдээллээс 3 хэсгийн мэдээллийг [www.shilen.gov.mn](http://www.shilen.gov.mn) сайтад тусгасан бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна. Хэрэгжилтийг хүснэгт №8-д харуулав.

#### Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт

Хүснэгт №8

Д/д	Бүлгийн нэр	Үнэлгээний хувь					Дундаж хувь
		100	70	30	0	Хамааралгүй	
1.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	-	-	-	-	100
2.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-
3.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	1	-	-	-	-	100
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-

5.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	-	-	-	-	100
<b>Нийт дундаж</b>		<b>5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100</b>

### 2.8. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Зам, тээврийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрх бүхий байгууллагаас 2025 онд хийсэн хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудит хийсэн бөгөөд Хүснэгт №9-д харуулав. Энэхүү үнэлгээг хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд тусгаагүй болно.

#### Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт №9

Д/д	Эрх бүхий байгууллага	Зөвлөмжийн агуулга	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
			Нийт	Үүнээс		
				Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	
1	ҮАГ	Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	3	2	1	67%
2	ҮАГ	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	3	1	2	33%
3	ЗГХХГ	Зам, тээврийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	11	2	9	18%
<b>Нийт</b>			<b>17</b>	<b>5</b>	<b>12</b>	<b>29.4</b>

Цаашид Зам, тээврийн салбарын хэмжээнд Үндэсний аудитын газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналт-шинжилгээ үнэлгээ болон хяналт, шалгалтын “зөвлөмж”-ийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

#### Гурав: Үнэлэлт, дүгнэлт

3.2. Бодлого, төлөвлөлтийн газрын үйл ажиллагаанд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн Хүснэгт №1-д заасан байдлаар үнэллээ.

3.2. Бодлого, төлөвлөлтийн газрын үйл ажиллагааны тайлангийн үнэлгээнээс харахад 2025 оны жилийн эцсийн байдлаар 6 үзүүлэлтийн 200 арга хэмжээний хэрэгжилт

90 хувьтай байгаа боловч ажлуудыг ач холбогдол, жингийн хувиар тооцсон жигнэсэн дундаж үнэлгээ 87.5 хувьтай байна. Жигнэсэн дундаж үнэлгээг дараах томъёоны дагуу бодсон.

$$\text{Жигнэсэн дундаж} = \frac{\sum(\text{Хэрэгжилтийн хувь} * \text{Жин})}{\sum \text{Жин}}$$

3.3. Бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 56 арга хэмжээ, 90-100 хувийн хэрэгжилттэй буюу , 70 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, хэрэгжилт тасарсан буюу 0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж үнэлгээ 91.8 хувьтай байна.

БТГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 33 арга хэмжээ буюу 84,8% нь жилийн эцсийн байдлаар хүрэх түвшиндээ хүрсэн болон хэрэгжих шатанд, 10 арга хэмжээ буюу 15,2% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

№	Зорилтууд	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт
1	Зорилт 1. Зам, тээврийн салбарын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлох, салбаруудын хоорондын уялдааг ханган төлөвлөх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлагаар хангана.	37	89.4%
2	Зорилт 2. Салбарын гадаад бодлого, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлж, салбарын дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд гадаад эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хувилбар боловсруулах, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдамжаар хангах.	9	91.1%
3	Зорилт 3. Салбарын шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, стандарт, норм, норматив, салбарын статистик тоон мэдээллийг нэгтгэн гаргах, бодлого, аргачлал, арга зүйг боловсронгуй болгох, салбарын цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, үйл ажиллагааны нэгдсэн системийг хөгжүүлэх, цахим мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, баяжуулах, бодлогын удирдамжаар хангана.	20	96.5%

3.4. БТГ-ын 2025 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 42 арга хэмжээний хэрэгжилт 68.7 хувьтай байсан бол хоёрдугаар улирлын байдлаар **88.6** хувьтай болж, өмнөх улирлаас 29.0 хувиар өссөн дүнтэй байсан бол гуравдугаар улирлын байдлаар 77.6 хувь болж, 12.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Жилийн эцсийн байдлаар шинээр баталсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 66 арга хэмжээний хэрэгжилт 91.8 хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд гуравдугаар улирлын хяналт-шинжилгээний мөрөөр өгсөн санал, зөвлөмжүүдээс ахиц гарсан арга хэмжээг 3.5-д, хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байгаа арга хэмжээний хэрэгжилтийг 3.6-д харуулав.

3.5. *Өмнө өгсөн зөвлөмжүүдээс дараах арга хэмжээний хэрэгжилтэд ахиц гарсан байна. Үүнд:*

- ✓ Салбарын урт, дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлно /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.16, шинэчилсэн 1.18/;
- ✓ “Салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтыг зохион байгуулах арга хэмжээ /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.17, шинэчилсэн 1.19/;
- ✓ Салбарт гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.18, шинэчилсэн 1.20/;

✓ Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх үйлдвэр, үйлчилгээг 2025 онд хөгжүүлэх төлөвлөгөө /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.19, шинэчилсэн 1.21/;

✓ Зам, тээврийн салбарын тэргүүлэх чиглэлээр судалгаа хийнэ. /Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.7, шинэчилсэн 1.25/;

3.6. Өмнө өгсөн зөвлөмжүүдээс дараах дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байна. Үүнд:

✓ Салбарын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл батлуулах /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2, шинэчилсэн 1.4/;

✓ Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын төлөвлөгөөг батлуулах /гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.5, шинэчилсэн 1.7/;

✓ Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.15, шинэчилсэн 1.17/;

3.7. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн сайдын хариуцан гүйцэтгэх болон холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцах нэгж, байгууллагыг тодорхой болгох чиглэлээр зохион байгуулалт хийж төлөвлөгөө батлуулаагүй байгаа тул хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд хүндрэлтэй байна.

### **Дөрөв. Санал, зөвлөмж**

Бодлого, төлөвлөлтийн газрын 2025 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан төсөл арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтыг сайжруулан, Яам түүний харьяа байгууллага тус бүрийн хариуцах чиг, үүргийг тодорхой тусгасан төлөвлөгөө батлуулах;

4.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем ([new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn))-д хууль тогтоомжид заасан хугацаанд бүрэн тайлагнах;

4.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Зам, тээврийн салбарын залуучуудыг дэмжих 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх үйлдвэр, үйлчилгээг 2025 онд хөгжүүлэх төлөвлөгөө, “Салбарын хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтыг зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах;

4.4. Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан журмын зургаадугаар хавсралтаар баталсан “Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмж”-ийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн тайлагнаж хэвших;

4.4.1. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл “Төрийн аудитын тайлан” хэсэгт заасны дагуу аудитын дүнд үндэслэн гарсан “зөвлөмж”-ийг хүлээж авсан Газар, хэлтэс “зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэн, төлөвлөгөөний



хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан зөвлөмжид заасан хугацаанд Аудитын байгууллагад хүргүүлж ажиллахыг тус тус зөвлөж байна.

---o0o---

